БАТЛАВ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

2025 оны ... дугаар сарын ...

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ ТАНХИМЫГ ТАНИН МЭДЭХҮЙН ҮЗҮҮЛЭНТЭЙ БОЛГОЖ ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Батлагдсан төсөв: 120.000.000 төгрөг

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Хамрах хүрээ	Гурвантэс, Сэврэй, Булган, Баяндалай, Ханхонгор, Цогтцэций, Ханбогд сумдын ЕБСургууль, Даланзадгад сумын 1,2,3,4,5-р дунд сургуулиудыг хамруулах
2.	Ажил гүйцэтгэх хугацаа	2025 оны 05 дугаар сарын 10-аас 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор дуусгавар болгож тухайн сумын Ерөнхий боловсролын дунд сургуульд хүлээлгэн өгсөн байна.
3.	Гүйцэтгэх ажил	➢ Танхимын самбар мэдээлэл нь шинжлэх ухаанаар бүрэн нотлогдсон, үнэн зөв, зураг мэдээлэл нь бусдын өмчлөх эрхэнд халдаагүй, зураг мэдээллийн эх үүсвэр нь баталгаажсан байна. ➢ Танхимын самбар, мэдээллүүдийн тайлбарыг монгол, англи хэл дээр хийсэн байна. ➢ Самбаруудын мэдээллийг тухайн бүс нутагт хамаарах биологийн олон янз байдал, үүнээс онцолж амьтан, ургамал, шувууд, шавьж, мөлхөгчид, аялал жуулчлалын чиглэлээр судалгаа явуулсан хүүлийн этгээд, хүмүүсийн судалгааны материалтай танилцаж зөвлөгөө, зөвлөмжийг авч, шаардлагатай зарим газруудад өөрсдөө судалгаа зохион байгуулж бүрдүүлсэн байна. ➢ Тухайн сумын онцлох: - Хөхтөн амьтад 20 ш - Шувууд 20 ш - Мэрэгчид болон хэвлээр явагчид 20 ш

4 ой
сэдэв

		- Ургамал 20 ш. нийт 4 бүлэг самбар. Самбар тус бүр 2400 см x 1200 см x 1.5 см хэмжээтэй өнгөт хавтан дээр хийгдсэн байна. - Тухайн сумын 9 гайхамшгийн зураг тайлбар - Тухайн сумын аялал жуулчлал, авто замын зураг 90x80 см - Тухайн сумын түүх соёлын дурсгалт зүйлүүд. 2400 см x 1200 см x 1.5 см хэмжээтэй өнгөт хавтан дээр хийгдсэн байна. - Тухайн сумын өвөрмөц чухал байгалийн үзэсгэлэнт газрын панорамм бүхий Light˙box самбар 2400 см x 80 см x 6 см хэмжээтэй. - Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх боломжтойгоор тайлбарласан самбар 1ш 80x90 см хэмжээтэй ➢ Төрөл бүрийн хог хаягдал, түүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг харуулсан самбар ➢ Танхим болон самбаруудын гэрэлтүүлгийг зөв тооцож, самбаруудын өндөр, өнгө, дизайныг эргономик үндэслэлтэй хийж гүйцэтгэнэ. ➢ Танхимыг хүлээлгэж өгөхдөө хариуцан ажиллах болон сургуулийн газар зүй, биологи, сурагчдын байгаль хамгаалах клубын багш нарт тухайн танхимтай хэрхэн холбож сургалт явуулах зөвлөмж, сургалтыг зохион байгуулна. ➢ Танхим нээгдэж байгаатай холбогдуулан дунд сургуулийн сурагчдад тухайн сумын байгаль орчны сургалтыг зохион байгуулна.
4.	Ажлын үе.шат, арга зүй	➢ Сумын дунд сургуулийн захирал, холбогдох багш нартай шууд эсвэл онлайн уулзалт зохион байгуулж шаардлагатай анги танхимыг гаргуулах, ➢ Эртний амьтан ургамал, биологийн олон янз байдал, түүх соёлын судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн багаас зөвлөгөө зөвлөмж авах. ➢ Багш захирлуудын саналыг сонсох ➢ Шаардлагатай бол өөрийн зардлаар судалгааны аялал зохион байгуулах ➢ Зураг төслөө сургуулийн захиргаанд танилцуулах ➢ Танхимыг байгуулах

		➢ Хүлээлгэн өгөх
5.	Үр дүн	- Хүүхэд залуучуудад багаасаа эх нутгаа танин мэдэх, хайрлан хамгаалах, эх оронч үзэл санаа суулгах орчин бий болно. - Түүх, соёлын олдворт газруудыг хамгаалах, сурталчлахын ач холбогдол, шаардлагатай танилцана. - Иргэд, хүүхэд, залуучуудыг Аялал жуулчлалын боловсролд оролцуулж, аялах хүсэл тэмүүлэлтэй болгож зөв аялах хэвшилд сургана. - Биологийн болон газар зүйн хичээлийн сургалтын агуулгыг баяжуулж орон нутгийн байгаль орчны сургалтын шинэ орчин бүрдэнэ. - Орон нутгийнхаа зэрлэг амьтад, шувууд, ургамал, шавьжтай танилцаж танин мэдэх, хамгаалах цаашлаад аялагч, судлаач, биологич мэргэжилтэй болох хүсэл тэмүүлэл бий болно. - Мэргэжлийн багш нарын сургалт явуулах шинэ орчин бий болж багш нарын мэдлэг, чадварын хүрээ нэмэгдэнэ.
6.	Хүлээн авах материал	Дунд сургуулийн гаргаж өгсөн танхимд зохицуулан дээр заасан самбарууд, гэрэлтүүлгийг стандартын дагуу бүрэн тохижуулж хүлээлгэн өгнө.
7.	Мэргэжлийн багийн шаардлага	➢ Тухайн сум, түүний орчны бүс нутаг, эсвэл говийн бүс нутагт байгаль орчин, аялал жуулчлал, соёлын өвийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн, шинжлэх ухааны судалгаа явуулж байсан туршлагатай, мэргэжлийн, аж ахуйн нэгж байгууллага, Төрийн бус байгууллага байх ➢ Баг нь интерьер дизайн, зураг чимэглэлийн мэргэжилтэй ажилтнууд, гүйцэтгэгчтэй байх. ➢ Баг нь биологийн төрөл зүйл ялангуяа шувууд, амьтад, мөлхөгчид, ургамал, шавьжийн гэрэл зургийн хуулиар хамгаалагдсан эрхтэй, өөрийн бий болгосон сантай байна. ➢ Баг нь шинжлэх ухааны үнэн зөв мэдээллийн эх сурвалжтай байна. ➢ Баг нь самбар мэдээллийн тайлбарыг англи хэл дээр үнэн зөв орчуулж гаргах чадвартай байна.

8.	Менежментийн төлөвлөгөөний боловсруулалтын явц болон гүйцэтгэлийн хяналт	1. Аймгийн Байгаль орчны газар, Сумын Ерөнхий боловсролын сургуульд үйл ажиллагааны явцаа танилцуулж шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана. 2. Ажил эхлэх болон гүйцэтгэлийн хяналтыг доорх бүрэлдэхүүнтэй хийж ажлын гүйцэтгэлийг акт тэмдэглэл үйлдэн хүлээн авна. ➢ Байгаль орчны газар ➢ Сумын ЕБСургуульд 3. Гүйцэтгэлийн хяналт тухайн ажлын зардлын 1,98% байна.

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА Х.ОТГОНМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Т. ПУНСАНЦОГВОО